



## НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

### Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 12 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай" А/357 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёругаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг ханган нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг дүүргийн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлийн дарга Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.


3. Энэ захирамж батлагдсантай хоблогдуулан "Зөвлөл шинэчлэн байгуулж, ажиллах журам батлах тухай" дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/62 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 08 сарын 21-ны өдрийн 1107 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



**ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙНГЫН  
АЖИЛЛАГААТАЙ ДҮҮРГИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга:	Дүүргийн Засаг дарга орлогч
Орлогч дарга:	Онцгой байдлын хэлтсийн дарга Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Цэргийн штабын дарга Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Боловсролын хэлтсийн дарга Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга Цагдаагийн хэлтсийн дарга Эрүүл мэндийн төвийн дарга Газар зохион байгуулалтын албаны дарга “Багахангай Тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал “Илч-орд” ОНӨААТҮГ-ын захирал Ус суваг ашиглалтын товчоо “Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн мастер “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал Мал эмнэлгийн тасгийн дарга УБТЗ-ын “Багахангай” өртөөний дарга, Нэгдүгээр хорооны Засаг дарга Хоёрдугаар хорооны Засаг дарга Улаан Загалмайн хорооны дарга
Нарийн бичгийн дарга:	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Онцгой байдлын хэлтсийн орлогч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 01 сарын 01 -ны өдрийн А/ДТ дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ДҮҮРГИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Байнгын ажиллагаатай дүүргийн салбар зөвлөл (цаашид “Дүүргийн салбар зөвлөл” гэх нь) нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон ажиллана.
- 1.2. Дүүргийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Дүүргийн Засаг дарга баталж, дүүргийн Засаг даргын орлогч удирдана.
- 1.3. Дүүргийн салбар зөвлөлийн ажлын алба нь Дүүргийн Онцгой байдлын хэлтэс байна.
- 1.4. Дүүргийн салбар зөвлөл нь Гамшгийн эрсдэлийг бууруулах дүүргийн зөвлөлийн дэд зөвлөл байх бөгөөд хэрэгжүүлсэн ажлаа тайлагнана.
- 1.5. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.
- 1.6. Дүүргийн салбар зөвлөл нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хурлаараа хэлэлцэж, зөвлөмж, тэмдэглэл гаргана.
- 1.7. Дүүргийн салбар зөвлөл нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.8. Дүүргийн салбар зөвлөл нь улирал бүр хуралдах бөгөөд, хуралд гишүүдийн 50-аас дээш хувь оролцсоноор хүчин төгөлдөр болно. Хурал үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын явцтай танилцан холбогдох асуудлаар шийдвэр гаргана.
- 1.9. Дүүргийн салбар зөвлөл нь ажлын шаардлагын улмаас ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.
- 1.10. Магнитуд нь 6.0 ба түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт болсон үед зөвлөлийн бүрэлдэхүүн нэн даруй дүүргийн Онцгой байдлын хэлтэст цугларна.

### Хоёр. Дүүргийн салбар зөвлөлийн эрх үүрэг

- 2.1.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах ажлыг дүүргийн нутгийн захиргааны байгууллагаар гүйцэтгүүлэх, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулан үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах

2.1.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх асуудлаар олон улсын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох

2.1.3. Монгол Улсын хууль тогтоомж, дүүргийн салбар зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар холбогдох агентлаг, хуулийн этгээдийн мэдээллийг сонсох, үүрэг, даалгавар өгөх, хяналт тавих

2.1.4. Холбогдох агентлаг, байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, биелэлтийг хангуулах

2.2. Дүүргийн салбар зөвлөл дараах эрхтэй байна. Үүнд:

2.2.1. Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол болон бусад шийдвэр, байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл сонсох, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих

2.2.2. Газар хөдлөлтийн бүс дэх барилга байгууламжийн зураг төсөл, барилга угсралтын ажил, хүлээн авах, хяналт болон стандарт норм, дүрмийн шинэчлэлийн талаарх мэдээлэл солилцох, хот төлөвлөлт, аюулгүй байдлын талаарх асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргах

Гурав. Дүүргийн салбар зөвлөлийн дарга дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ

3.1.1. Дүүргийн салбар зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах

3.1.2. Дүүргийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, гишүүдэд үүрэг чиглэл өгч, биелэлтэд хяналт тавих

3.1.3. Зөвлөлийн үйл ажиллагааны талаар Нийслэлийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөл, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл болон дүүргийн Засаг даргад танилцуулах

3.1.4. Дүүргийн салбар зөвлөлийн хурлыг таслах, хоцрох, зөвлөлийн шийдвэр төлөвлөгөөний хүрээнд хариуцсан ажлаа тасалдуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох талаар удирдлагад нь мэдэгдэх, хэрэгжилтэд хяналт тавих

Дөрөв. Дүүргийн салбар зөвлөлийн гишүүний эрх, үүрэг

4.1. Дүүргийн салбар зөвлөлийн гишүүн дараах үүрэгтэй байна. Үүнд:

4.1.1. Газар хөдөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаар хийсэн ажлаа нийслэлийн газар хөдөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай салбар зөвлөлд тайлагнах

4.1.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах асуудлаар гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох

4.1.3. Дүүргийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа, хуралдаанд идэвх, санаачилгатай оролцох

4.1.4. Дүүргийн салбар зөвлөлийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд зөвлөлийн даргад албан бичгээр урьдчилан мэдэгдэх, хэлэлцэж буй асуудлаар саналаа бичгээр ирүүлэх

4.2. Дүүргийн салбар зөвлөлийн гишүүн дараах эрхтэй байна. Үүнд:

4.2.1. Зөвлөлийн үйл ажиллагаатай хоблоотой асуудлаар дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас мэдээлэл авах, үүрэг даалгавар өгөх, хяналт тавих

4.2.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах эрсдэлийг бууруулах асуудлаар дүүргийн салбар зөвлөлийн хуралд асуудал танилцуулах, санлал гаргах

4.2.3. Дүүргийн салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах

Тав. Дүүргийн салбар зөвлөлийн Ажлын албаны эрх, үүрэг

5.1. Дүүргийн салбар зөвлөлийн ажлын алба дараах үүрэгтэй байна. Үүнд:

5.1.1. Дүүргийн салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоож, хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг дүүргийн салбар зөвлөлийн даргаар батлуулах

5.1.2. Дүүргийн салбар зөвлөлийн төлөвлөгөө, шийдвэрийг боловсруулж, батлуулан хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг нэгтгэх, танилцуулах ажлыг зохион байгуулах

5.1.3. Дүүргийн салбар зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж, зөвлөлийн даргад танилцуулах

5.1.4. Дүүргийн салбар зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж, зөвлөлийн даргад танилцуулах

5.1.4. Дүүргийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулах

5.1.5. Дүүргийн салбар зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр дүүргийн салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулах, зөвлөлийн баримт бичгийг зохих журмын дагуу эмхлэн хадгалах

5.2. Дүүргийн салбар зөвлөлийн ажлын алба дараах эрхтэй байна. Үүнд:

5.2.1. Дүүргийн салбар зөвлөлийн ажилд шаардлагатай бичиг баримт, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах

5.2.2. Үйл ажиллагаа зохион байгуулахад тус зөвлөлийн дарга, гишүүдээс шаардлагатай дэмжлэг, туслалцаа авах

5.2.3. Дүүргийн салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, санал гаргах